



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2023/01/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.dornogovi@audit.gov.mn
Сайншанд сум
2022 он

Дарга, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 261665, 70522734
Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020
Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Т.Оюунтуяа
Утас: 99048991
Цахим хаяг: oyuntuya@esanhuu.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДОРНОГОВЬ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гууламж,
3 дугаар баг, Сайшсан сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахын хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.08.24 № 1-6/384

тантай _____-ны № _____-т

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГА
Ч.ЭНХМЭНД ТАНАА**

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитад чухал нөлөө үзүүлсэн асуудлуудыг авч үзэх бөгөөд 2022 онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн холбогдох эрх зүйн актуудын хэрэгжилтийг ханган, мөрдсөн эсэх асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Дорноговь аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь нягтлан бодох бүртгэлдээ Green Finance-Gov 2.0 программыг ашигладаг ба уг программ хангамж нь Сангийн сайдын 2014 оны 5, 2015 оны 07, 55, 388 дугаар тушаалуудаар баталсан маягт аргачлалын дагуу аккруэл суурьт шалгах баланс тодруулгууд, ерөнхий дэвтэр, тохируулах бичилтүүдийг бэлтгэхгүй байна. Энэ нь Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 47 дугаар тушаалаар баталсан "Аж ахуйн нэгж

010020002

байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага"-ыг хангаагүй байна.

Санхүүгийн тайланд тусгагдсан төлбөртэй үйлчилгээний авлагын 16.6 хувь болох 428.5 сая төгрөг нь 1 жилээс дээш хугацаа хэтэрсэн, үүнээс 3 жилээс дээш 74.4 сая төгрөгийн авлага байгаа ба 72.6 сая төгрөгийн авлагыг хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр хандсан байна. Авлагын үлдэгдэлд найдваргүй авлагын нөөц байгуулаагүй нь авлагыг бодитой тайлагнаагүй, хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" заалт, УСНББОУС 1-ын 27-д "Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг" заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 65 нэр төрлийн 163.1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аймгийн Засаг дарга, Нийгмийн даатгалын сангийн дарга хооронд байгуулсан 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 4 зорилт, 6 хөтөлбөрийн 22 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлийн биелэлт 90.6 хувьтай байна

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. Ингэхэд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,640,315,354.19	13,220,608,010.30
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,414,536,243.76	6,545,044,603.18
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,414,536,243.76	6,545,044,603.18
31210	Төгрөг	5,414,536,243.76	6,545,044,603.18
31211	Төрийн сангийн харилцах	15,597,406.24	7,363,682.21
31213	Арилжааны банк дахь харилцах	5,398,938,837.52	6,537,680,920.97
33	АВЛАГА	7,206,180,049.72	6,656,385,337.51
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	2,160,606,654.22	2,589,093,784.55
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5,000,382,901.52	4,023,012,841.52
33500	Бусад авлага	45,190,493.98	44,278,711.44
33510	Байгууллагаас авах авлага	45,190,493.98	44,278,711.44
35	БАРАА МАТЕРИАЛ	19,599,060.71	19,178,069.61
35400	Хангамжийн материал	19,599,060.71	19,178,069.61
35410	Бичиг хэргийн материал	1,883,640.01	1,713,440.01
35420	Аж ахуйн материал	13,334,841.00	14,087,090.00
35430	Сэлбэг хэрэгсэл	1,116,980.00	1,281,980.00
35440	Түлш, шатах тослох материал	669,000.00	120,000.00
35470	Бусад хангамжийн материал	2,594,599.70	1,975,559.60
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	402,665,225.52	433,021,803.96
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	402,665,225.52	433,021,803.96
39200	Биет хөрөнгө	377,465,225.52	407,821,803.96
39201	Барилга, байгууламж, орон сууц	351,060,639.99	351,060,639.99
39202	Хуримтлагдсан элэгдэл	-35,636,655.90	-47,628,844.14
39203	Авто-тээврийн хэрэгсэл	69,900,000.00	69,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-69,900,000.00	-69,900,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	152,239,706.38	194,885,183.38
39206	Хуримтлагдсан элэгдэл	-109,096,104.10	-103,769,104.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	62,652,100.00	61,224,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-43,754,460.85	-47,950,170.45
39300	Биет бус хөрөнгө	25,200,000.00	25,200,000.00
39301	Програм хангамж	5,427,586.00	5,427,586.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,427,586.00	-5,427,586.00
39303	Бусад биет бус хөрөнгө	25,200,000.00	25,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,042,980,579.71	13,653,629,814.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	118,454,796.60	174,216,482.36
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	118,454,796.60	174,216,482.36
41300	Өглөг	12,105,841.38	14,071,428.49
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	12,105,841.38	14,071,428.49
41400	Урьдчилж орсон орлого	106,348,955.22	160,145,053.87
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	106,348,955.22	160,145,053.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	12,924,525,783.11	13,479,413,331.90
51	Засгийн газрын хувь оролцоо	12,924,525,783.11	13,479,413,331.90
51100	Засгийн газрын оруулсан капитал	366,264,211.87	366,264,211.87
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	366,264,211.87	366,264,211.87
51200	Хуримтлагдсан үр дүн	12,535,616,423.84	13,090,503,972.63
51210	Өмнөх үеийн үр дүн	11,901,069,253.19	12,535,477,614.84
51220	Тайлант үеийн үр дүн	634,547,170.65	555,026,357.79
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	22,645,147.40	22,645,147.40
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,042,980,579.71	13,653,629,814.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	67,501,869,248.88	86,186,476,613.72
11	ТАТВАРЫН ОРЛОГО	54,339,470,096.73	58,105,397,906.17
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	54,339,470,096.73	58,105,397,906.17
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	37,739,794,943.17	39,412,806,943.71
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,678,711,862.27	4,144,740,698.62
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,595,668,856.90	4,059,748,028.15
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	729,113,540.88	821,566,887.59
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	8,596,180,893.51	9,666,535,348.10
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	68,608,171.15	86,932,011.55
120	Нийтлэг татварын бус орлого	68,608,171.15	86,932,011.55
120002	Хүүгийн орлого	24,662,321.11	695,869.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,325,855.04	37,909,821.25
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	24,995,355.04	37,866,821.25

1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	330,500.00	43,000.00
120009	Бусад орлого	18,619,995.00	48,326,321.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,093,790,981.00	27,994,146,696.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	9,773,588,370.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	9,773,588,370.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,225,000.00	2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,940,000.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00	0.00
1330	Төсвийн захирагчдаас	12,427,093,881.00	17,510,139,626.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,427,093,881.00	17,510,139,626.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	656,472,100.00	708,418,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	656,472,100.00	701,583,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0.00	6,835,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	66,869,703,149.56	85,631,450,255.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	66,869,703,149.56	85,631,450,255.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	674,670,453.10	691,999,911.65
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	474,471,444.00	516,739,821.23
210101	Үндсэн цалин	366,307,249.00	373,254,045.36
210102	Нэмэгдэл	81,980,195.00	62,684,997.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	20,064,000.00	27,060,000.00
210104	Урамшуулал	6,120,000.00	53,740,778.87
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	63,071,104.22	66,413,236.10
210201	Тэтгэврийн даатгал	43,638,897.02	45,619,839.75
210202	Тэтгэмжийн даатгал	4,856,475.02	5,354,585.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,885,180.02	4,125,404.49
210204	Ажилгүйдлийн даатгал	971,295.00	1,020,513.21
210205	Эрүүл мэндийн даатгал	9,719,257.16	10,292,893.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,050,285.74	29,849,441.41
210301	Гэрэл, цахилгаан	4,339,939.74	5,668,744.41
210302	Түлш, халаалт	22,110,346.00	22,505,901.00
210303	Цэвэр, бохир ус	1,600,000.00	1,674,796.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,235,803.00	23,433,349.25
210401	Бичиг хэрэг	5,412,132.00	4,974,800.00
210402	Тээвэр, шатахуун	10,383,600.00	9,946,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,432,625.00	4,409,974.25
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	298,500.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,708,946.00	3,862,575.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,292,410.00	6,199,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	383,000.00	0.00
210604	Урсгал засвар	13,909,410.00	6,199,850.00
2107	Томилолт, зочны зардал	1,556,000.00	2,752,900.00
210702	Дотоод албан томилолт	1,556,000.00	2,752,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,352,101.26	15,411,742.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,194,673.76	7,557,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,390,037.00	1,400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	77,082.00
210807	Газрын төлбөр	50,000.00	44,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,932,760.00	4,997,644.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,636,130.50	1,335,416.10
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,641,304.88	31,199,571.56
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,900,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	34,641,304.88	29,299,571.56
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,195,032,696.46	84,939,450,344.28
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,194,754,805.00	69,638,650,616.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	54,164,719,692.00	69,600,584,773.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,745,113.00	7,660,408.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,290,000.00	30,405,435.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,000,277,891.46	15,300,799,728.28
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,000,277,891.46	15,300,799,728.28
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	632,166,099.32	555,026,357.79
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	2,381,071.33	0.00
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	2,381,071.33	0.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	634,547,170.65	555,026,357.79

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	65,844,712,843.44	86,767,575,825.87
11	ТАТВАРЫН ОРЛОГО	52,589,033,557.70	57,746,314,772.59
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	52,589,033,557.70	57,746,314,772.59
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	36,880,382,960.82	39,182,192,983.50

112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,324,719,502.11	4,118,485,364.04
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	3,230,980,053.57	4,030,856,356.12
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	665,278,586.92	817,718,579.23
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	8,487,672,454.28	9,597,061,489.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	98,481,385.74	107,809,753.28
120	Нийтлэг татварын бус орлого	98,481,385.74	107,809,753.28
120002	Хүүгийн орлого	24,662,321.11	695,869.30
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	73,819,064.63	107,113,883.98
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	73,488,564.63	107,070,883.98
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	330,500.00	43,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,157,197,900.00	28,913,451,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	72,500,800.00	10,751,805,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	72,500,800.00	10,751,805,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,225,000.00	2,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	9,940,000.00	2,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	285,000.00	0
1330	Төсвийн захирагчдаас	12,418,000,000.00	17,451,227,500.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,418,000,000.00	17,451,227,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	656,472,100.00	708,418,700.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	656,472,100.00	701,583,100.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	0	6,835,600.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	66,905,429,659.83	85,637,067,466.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	66,905,429,659.83	85,637,067,466.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	639,259,361.72	663,157,432.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	475,151,499.22	516,873,879.87
210101	Үндсэн цалин	381,666,399.22	375,171,253.20
210102	Нэмэгдэл	64,045,100.00	62,300,450.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	23,320,000.00	26,832,000.00
210104	Урамшуулал	6,120,000.00	52,570,176.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,391,049.00	66,413,236.91
210201	Тэтгэврийн даатгал	41,764,568.20	45,619,840.56
210202	Тэтгэмжийн даатгал	5,159,739.75	5,354,585.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,124,048.34	4,125,404.49
210204	Ажилгүйдлийн даатгал	1,029,452.31	1,020,513.21
210205	Эрүүл мэндийн даатгал	10,313,240.40	10,292,893.62
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	28,050,285.74	29,849,441.41
210301	Гэрэл, цахилгаан	4,339,939.74	5,668,744.41
210302	Түлш, халаалт	22,110,346.00	22,505,901.00
210303	Цэвэр, бохир ус	1,600,000.00	1,674,796.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,153,367.00	23,221,798.25
210401	Бичиг хэрэг	6,850,242.00	4,804,600.00
210402	Тээвэр, шатахуун	9,967,600.00	9,397,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,432,625.00	4,409,974.25
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	298,500.00	240,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,604,400.00	4,370,224.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,241,190.00	8,069,850.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,499,980.00	1,870,000.00
210604	Урсгал засвар	13,741,210.00	6,199,850.00
2107	Томилолт, зочны зардал	1,556,000.00	2,752,900.00
210702	Дотоод албан томилолт	1,556,000.00	2,752,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,715,970.76	14,076,326.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	22,194,673.76	7,557,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,390,037.00	1,400,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	148,500.00	77,082.00
210807	Газрын төлбөр	50,000.00	44,400.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	4,932,760.00	4,997,644.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	1,900,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00	1,900,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	66,266,170,298.11	84,973,910,034.01
2132	Бусад урсгал шилжүүлэг	54,266,688,106.65	69,673,110,305.73
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	54,202,355,887.70	69,603,460,938.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,745,113.00	7,660,408.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,297,105.95	31,583,524.73
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,290,000.00	30,405,435.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,999,482,191.46	15,300,799,728.28
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,999,482,191.46	15,300,799,728.28
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	-1,060,716,816.39	1,130,508,359.42

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1,060,716,816.39	1,130,508,359.42
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,475,253,060.15	5,414,536,243.76
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,414,536,243.76	6,545,044,603.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	11,906,830,811.25	12,295,740,170.52
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-5,761,558.06	-5,761,558.06
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	11,901,069,253.19	12,289,978,612.46
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	634,547,170.65	634,547,170.65
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	12,535,616,423.84	12,924,525,783.11
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	12,535,616,423.84	12,924,525,783.11
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-138,809.00	-138,809.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	12,535,477,614.84	12,924,386,974.11
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	555,026,357.79	555,026,357.79
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	366,264,211.87	22,645,147.40	13,090,503,972.63	13,479,413,331.90

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	70,364,017,900.00	70,302,684,213.44	61,333,686.56
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,364,017,900.00	70,302,684,213.44	61,333,686.56
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	677,305,600.00	661,157,432.44	16,148,167.56
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	529,934,100.00	516,873,879.87	13,060,220.13
210101	Үндсэн цалин	393,371,800.00	375,171,253.20	18,200,546.80
210102	Нэмэгдэл	76,663,900.00	62,300,450.00	14,363,450.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,576,800.00	26,832,000.00	13,744,800.00
210104	Урамшуулал	19,321,600.00	52,570,176.67	-33,248,576.67
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	66,685,300.00	66,413,236.91	272,063.09
210201	Тэтгэврийн даатгал	45,346,100.00	45,619,840.56	-273,740.56
210202	Тэтгэмжийн даатгал	5,334,800.00	5,354,585.03	-19,785.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,267,800.00	4,125,404.49	142,395.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,067,000.00	1,020,513.21	46,486.79
210205	Эрүүл мэндийн даатгал	10,669,600.00	10,292,893.62	376,706.38
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,260,000.00	29,849,441.41	410,558.59
210301	Гэрэл, цахилгаан	5,866,000.00	5,668,744.41	197,255.59
210302	Түлш, халаалт	22,550,900.00	22,505,901.00	44,999.00
210303	Цэвэр, бохир ус	1,843,100.00	1,674,796.00	168,304.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,237,500.00	21,221,798.25	15,701.75
210401	Бичиг хэрэг	4,811,500.00	4,804,600.00	6,900.00
210402	Тээвэр, шатахуун	9,399,300.00	9,397,000.00	2,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,411,700.00	4,409,974.25	1,725.75
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	240,000.00	240,000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,375,000.00	2,370,224.00	4,776.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,083,200.00	8,069,850.00	13,350.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,883,200.00	1,870,000.00	13,200.00
210604	Урсгал засвар	6,200,000.00	6,199,850.00	150.00
2107	Томилолт, зочны зардал	2,755,000.00	2,752,900.00	2,100.00
210702	Дотоод албан томилолт	2,755,000.00	2,752,900.00	2,100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,450,500.00	14,076,326.00	2,374,174.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,586,700.00	7,557,200.00	29,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,400,000.00	1,400,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	77,082.00	72,918.00
210807	Газрын төлбөр	50,000.00	44,400.00	5,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,263,800.00	4,997,644.00	2,266,156.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,900,000.00	1,900,000.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,900,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	69,686,712,300.00	69,641,526,781.00	45,185,519.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,686,712,300.00	69,641,526,781.00	45,185,519.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	69,648,572,800.00	69,603,460,938.00	45,111,862.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,734,000.00	7,660,408.00	73,592.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,405,500.00	30,405,435.00	65.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	70,364,017,900.00	58,989,996,430.18	11,374,021,469.82
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	10,751,805,100.00	10,751,805,100.00	0.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	10,751,805,100.00	10,751,805,100.00	0.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	59,612,212,800.00	48,156,770,566.19	11,455,442,233.81
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	59,605,377,200.00	48,149,934,966.19	11,455,442,233.81
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	6,835,600.00	6,835,600.00	0.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	81,420,763.99	-81,420,763.99
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	81,377,763.99	-81,377,763.99
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	43,000.00	-43,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	5,414,536,159.76	-5,414,536,159.76
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	6,545,044,603.18	-6,545,044,603.18
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	85	85	0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0
610001	Төсвийн байгууллага	1	1	0
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	42	42	0
620001	Удирдах ажилтан	1	1	0
620002	Гүйцэтгэх ажилтан	33	33	0
620003	Үйлчлэх ажилтан	8	8	0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	42	42	0
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	34	32	2
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8	10	-2

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 3 зөрчил¹ илэрснээс 3 зөвлөмж өгсөн.

3.3 Зөвлөмж

1. Санхүүгийн программтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Дорноговь аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь нягтлан бодох бүртгэлдээ Green Finance-Gov 2.0 программыг ашигладаг ба уг программ хангамж нь Сангийн сайдын 2014 оны 5, 2015 оны 07, 55, 388 дугаар тушаалуудаар баталсан маягт аргачлалын дагуу аккурэл суурьт шалгах баланс тодруулгууд, ерөнхий дэвтэр, тохируулах бичилтүүдийг бэлтгэхгүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2018 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 47 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн программд тавигдах шаардлага”-ыг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 14.3-т заасан мэдээлэл боловсруулалт, холбогдох тайлан мэдээг бүрэн гүйцэт гаргах холбогдох программын сайжруулалт хийлгэх.

2. Авлагатай холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд тусгагдсан төлбөртэй үйлчилгээний авлагын 16.6 хувь болох 428.5 сая төгрөг нь 1 жилээс дээш хугацаа хэтэрсэн, үүнээс 3 жилээс дээш 74.4 сая төгрөгийн авлага байгаа ба 72.6 сая төгрөгийн авлагыг хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр хандсан байна. Авлагын үлдэгдэлд найдваргүй авлагын нөөц байгуулаагүй нь авлагыг бодитой тайлагнаагүй, хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” заалт, УСНББОУС 1-ын 27-д “Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг” заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байх, хэмжилт ба үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: НБББББ-т тусгаснаар найдваргүй авлагын нөөцийг дансанд тусгах журмыг баталж мөрдөх, найдваргүй авлагын нөөц байгуулж авлагын үлдэгдлийг бодитой илэрхийлэх.

3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 65 нэр төрлийн 163.1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 “Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай нийцэхгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг мөрдөж холбогдох арга хэмжээг авч ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтүүдийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.
Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Дорноговь аймгийн нийгмийн даатгалын хэлтэс нь нягтлан бодох бүртгэлдээ Green Finance-Gov 2.0 программыг ашигладаг ба уг программ хангамж нь Сангийн сайдын 2014 оны 5, 2015 оны 07, 55, 388 дугаар тушаалуудаар баталсан маягт аргачлалын дагуу аккурэл суурьт шалгах баланс тодруулгууд, ерөнхий дэвтэр, тохируулах бичилтүүдийг бэлтгэхгүй байна.	1							1					
Санхүүгийн тайланд тусгагдсан төлбөртэй үйлчилгээний авлагын 16.6 хувь болох 428.5 сая төгрөг нь 1 жилээс дээш хугацаа хэтэрсэн, үүнээс 3 жилээс дээш 74.4 сая төгрөгийн авлага байгаа ба 72.6 сая төгрөгийн авлагыг хууль шүүхийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр хандсан байна. Авлагын үлдэгдэлд найдваргүй авлагын нөөц байгуулаагүй нь авлагыг бодитой тайлагнаагүй, хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангахгүй байна.	1							1					
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээ бүрэн нөхсөн 65 нэр төрлийн 163.1 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил бүртгэлтэй байгаа бөгөөд тус хөрөнгийг актлах, дахин үнэлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллаагүй байна.	1							1					
Дүн	3							3					